

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..	8
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	11
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
3. Менежментийн захидал	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
НБУГ	Нисэх буудлуудын удирдах газар
ЧХОУНБ	Чингис хаан олон улсын нисэх буудал
ГТҮА	Газрын тусгай үйлчилгээний алба



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭД ДАРГА
Ё.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2020.03.13 № 06/883
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалтай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- Он удаан жил болсон авиа компаниудаас авах 9,026.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй,
- Аж ахуйн нэгж, иргэнтэй холбоотой 753.7 сая төгрөгийн авлагыг актаар баталгаажуулаагүй,
- Тендер шалгаруулалтгүй 367.6 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан,
- ИНЕГ-ын харьяа байгууллагуудтай холбоотой 93.5 сая төгрөгийн авлага, 240.1 сая төгрөгийн өглөгийг ИНЕГ-ын авлага, өглөгийн систем хоорондын тооцоогоор хааж, бэлэн бус тооцооны хэлбэрээр нэхэмжлэн авахаар тохирч, системийн авлагыг 140.6 сая төгрөгийн цэвэр дүнгээр нэгтгэж толилуулсан,
- 2.7 сая төгрөгийн газрын төлбөрийг бүртгэлд тусгаагүй зэрэг нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг толилуулга ба илчлэл батламж мэдэгдлийг хангахгүй батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Нисэх буудлуудын удирдах газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Иргэний нисэхийн үндэсний төвийн дэд дарга Ё.Эрдэнэбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг заавар журмын дагуу хийх, найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах, программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Нисэх буудлуудын удирдах газрын удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал, чанарын хяналтын менежер Д.Нямдорж, аудитор Л.Хаш-Эрдэнэ, туслах аудитор Ө.Рагчаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нисэх буудлуудын удирдах газар нь 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2/144 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Нисэх буудлуудын удирдах газар нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/151 дүгээр тушаалаар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

ИНЕГ-ын даргын 2018 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн А/369 дугаар тушаалаар ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн Нисэх буудлуудын удирдах газрыг шинээр байгуулагдсантай холбогдуулан тус газрын зохион байгуулалтын бүтцийг шинээр баталж, 4 хэлтэс, 6 тасаг, Чингис хаан Олон улсын нисэх буудал, орон нутгийн нисэх 15 буудал, Газрын тусгай үйлчилгээний алба, Аюулгүй байдал, хамгаалалтын алба, Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны алба, нийт 20 нэгжийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тушаалын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Нисэх буудлуудын удирдах газар нь 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс татан буугдаж, Иргэний нисэхийн үндэсний төв гэсэн нэрээр шинэ зохион байгуулагдаж, Иргэний нисэхийн үндэсний төвийн дэд даргаар Ё.Эрдэнэбат, ерөнхий нягтлан бодогчоор Г.Халиунбигэр нар тус тус томилогдсон байна.

Нисэх буудлуудын удирдах газрын зорилго нь Нисэх буудлуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангуулах ажиллагааг олон улсын болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагад нийцүүлэх, салбарын бодлоготой уялдуулан үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хангахад оршино.

Нисэх буудлуудын удирдах газар нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажиллажээ. Үүнд:

- Нисэх буудлуудын хөгжлийн хэтийн төлөв, стратегийг тодорхойлох, үйлдвэрлэл, үйлчилгээг боловсронгуй болгох;
- Нисэх буудлуудын үйл ажиллагааг олон улсын жишиг, стандартын түвшинд нийцүүлэн удирдлага зохион байгуулалт, бодлогын чиглэлээр хангах;
- Үйлдвэрлэлийн хэвийн тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулах, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл, Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөл, Агаарын хөлөг, шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулах ажлыг зохион байгуулж, гишүүн байгууллагатай хамтран ажиллах;

Нисэх буудлуудын удирдах газар нь ИНЕГ-ын даргатай байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээний хүрээнд тусгай захиалгат ажил үйлчилгээ 15, бусад 58 ажил тусгагдсан ба төлөвлөгөөний хэрэгжилт 95.7%-ийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн

нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд"-ийг 2 дугаар хавсралтаар баталсан

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хувь хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Нисэх буудлуудын удирдах газар нь ИНЕГ-ын даргын 2017 оны оны А/901 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Нисэх буудлуудын удирдах газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив ХХК-ийн "Veritech erp" программ хангамж ашигладаг байна.

Нисэх буудлуудын удирдах газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад авлага, өглөгийн бүртгэл, бараа материал, үндсэн хөрөнгө, жижиг мөнгөн сан, зардлын дансанд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан дотоод аудит, хяналт шалгалт хийх хуваарийн дагуу Нисэх буудлуудын удирдах газар болон түүний харьяа 16 алба, салбар нэгжид төлөвлөгөөт шалгалт хийж гүйцэтгэсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нисэх буудлуудын удирдах газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 20 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 545,115.7 сая төгрөгөөс тооцон 5,451.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 5,379.0 сая төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн сонгосон суурь үзүүлэлтээс тооцоолсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд

Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,321.4 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна. Оны эхний болон эцсийн үзүүлэлтийг харьцуулахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансад материаллаг өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	/сая төгрөг/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,999.4	15,040.1	11,040.7
2	Дансны авлага	18,132.9	16,890.8	(1,242.0)
4	Урьдчилж гарсан зардал	67.3	27.4	(39.9)
5	Бараа материал	3,431.1	4,086.0	654.9
6	Үндсэн хөрөнгө	507,950.5	501,858.3	(6,092.2)
7	Нийт хөрөнгө	533,581.2	537,902.6	4,321.4
8	Богино хугацаат өр төлбөр	508.6	278.8	(229.8)
12	Урт хугацаат өр төлбөр	500.5	1,230.9	730.4
15	Эздийн өмч: - төрийн	406,720.9	406,720.9	-
16	Эздийн өмчийн бусад хэсэг	2,974.1	2,715.9	(258.2)
18	Хуримтлагдсан ашиг	122,877.0	126,956.1	4,079.1
19	Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	533,581.2	537,902.6	4,321.4

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 3.8 дахин буюу 11,040.7 сая төгрөгөөр өссөн нь Чингис хаан Олон улсын нисэх буудлын урд оны авлагын үлдэгдлээс 2,519.7 сая төгрөгийн авлагыг барагдуулсан, тайлант оны мөнгөн хөрөнгийн орлого, зарлага, эцсийн үлдэгдэл өссөн нь ИНЕГ-ын даргын 2018 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн А/369 дугаар тушаалаар батлагдсан шинэ бүтэц зохион байгуулалтын дагуу 2019 оны эхний хагас жилийн тайланд 20 салбар нэгжийн санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой байна.

2018 онд байгуулагдсан байсан өмнөх оны санхүүгийн тайланг нэгтгэдэггүй байсан юм уу.

Авлагын дансны үлдэгдэл 1,242.0 сая төгрөгөөр буурсан нь Чингис хаан Олон улсын нисэх буудал нь дотоодын авиа компаниас авах авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 654.9 сая төгрөгөөр өссөн нь дуусаагүй үйлдвэрлэл 1.0 сая, аж ахуйн материал 10.1 сая, сэлбэг хэрэгсэл 417.0 сая, түлш шатахуун 374.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, бэлэн бүтээгдэхүүн 2.5 сая, бусад хангамжийн материал 145.5 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 6,092.2 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2019 оны 83, 351, 443 дугаар тогтоолуудаар 287.3 сая төгрөгийн хөрөнгийг бусад төрийн байгууллагуудад шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2019 он А-5/1435 дугаар албан бичгээр 1,132.7 сая төгрөгийн хөрөнгө акталсан дүнгээр хөрөнгө буурч, худалдан авсан 3,421.4 сая, шилжүүлж авсан 353.4 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 32.3 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эздийн өмчийн бусад хэсэг 258.2 сая төгрөг буурсан нь 2016 онд БНХАУ-ын Засгийн газрын тусламжаар хүлээн авсан агаарын хөлөгт үйлчлэх 11 ширхэг тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тайлант хугацааны элэгдлийн дүнгээр хойшлогдсон орлогыг хорогдуулж бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмчийн дүн тайлант үеийн цэвэр ашиг 4,512.1 сая төгрөгөөс МИАТ ХК-тай холбоотой шүүхийн шийдвэрийн дагуу өмнөх оны хуримтлагдсан ашгийг 433.0 сая төгрөгөөр бууруулах нягтлан бодох бүртгэлийн залруулга бичилт хийснээс шалтгаалан хуримлагдсан ашиг 4,079.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны тодотгосон зорилтод түвшний төлөвлөгөөнд буулт хөөрөлтийн орлого 12,691.9 сая, зорчигч үйлчилгээний буудлын хураамж 12,357.4 сая, үйл ажиллагааны бусад орлогыг 12,582.8 сая төгрөг нийт 37,632.1 сая төгрөгийн орлого төлөвлөж, гүйцэтгэлээр буулт хөөрөлтийн орлого 15,877.8 сая төгрөг, зорчигч үйлчилгээний буудлын хураамж 14,076.5 сая төгрөг, үйлчилгээний бусад орлого 16,855.3 сая төгрөг нийт 46,809.6 сая төгрөгийн орлоготой.

Орлогын төлөвлөгөөг 9,177.5 сая төгрөг буюу 24.4 хувиар давуулсан биелүүлсэн байна. Дотоодын болон гадаад авиа компаниудын гүйцэтгэсэн нислэгийн тоо төлөвлөсөн хэмжээнээс давсан нь орлогыг өсгөх шалтгаан болжээ.

Тайлант оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардалд 67,314.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 62,063.5 сая төгрөг зарцуулж 5,250.9 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

Урсгал зардал 5,250.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь төлөвлөсөн цалингийн өсөлтийг 2 дугаар улирлаас нэмж тооцоноос цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,915.8 сая, шинэ нисэх буудал бүрэн ашиглалтад ороогүй тул байр ашиглалтын зардал 405.1 сая, тайлант онд хэрэгжээгүй худалдан авах ажиллагааны эд хогшил, зөөлөн эдлэл худалдан авах, урсгал засвар хийх 1,053.0 сая, хангамжийн бараа материалын зардлыг 279.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд нислэгийн тоо нэмэгдсэнээс бараа үйлчилгээний бусад зардал 49.5 сая, бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй холбоотой ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэгийн зардал 15.4 сая, дотоод томилолтын зардал 8.8 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 20 эрсдэл тогтоож, гүйцэтгэх үе шатанд 20 горим сорил хэрэгжүүлжээ.

Нисэх буудлуудын удирдах газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн нэгтгэсэн тайланд Нисэх буудлуудын удирдах газар, Чингис хаан Олон улсын нисэх буудал, орон нутгийн 15 нисэх буудал, Газрын тусгай үйлчилгээний алба, Аюулгүй байдал, хамгаалалтын алба, Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Аудитаар орон нутгийн 3 нисэх буудлын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, нисэх буудлуудын удирдах газар болон 3 албаны санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 13

нисэх буудлын санхүүгийн тайланд Зөрчилгүй, Чингис хаан олон улсын нисэх буудлын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 12,986.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,423.0 сая төгрөгийн алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 210.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 9,349.1 сая төгрөгийн алдаа болон бусад зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 9 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Нисэх буудлуудын удирдах газар нь нэгтгэсэн тайлангаар ТӨБЗГ-ын 2019 оны 83, 351, 443 дугаар тогтоолуудаар 287.3 сая төгрөгийн хөрөнгийг бусад төрийн байгууллагуудад шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2019 он А-5/1435 дугаар албан бичгээр акталсан 1,132.7 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд толилуулаагүй. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, толилуулга ба илчлэл батламж мэдэгдлийг хангахгүй, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” -ын үндсэн хөрөнгийн тодруулга тайлан бэлтгэх заавартай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулга хийлгэсэн.

- Газрын тусгай үйлчилгээний алба нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгад элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгөнд 14.7 сая төгрөгийн элэгдэл илүү тооцсон, хойшлогдсон орлогоор бүртгэсэн үндсэн хөрөнгөнд 327.5 сая төгрөгийн 3 жилийн элэгдэл нөхөж байгуулж тайлант жилийн үр дүнг бууруулсан, 7.9 сая төгрөгөөр хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон, Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д заасан холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулга хийлгэсэн.

- Газрын тусгай үйлчилгээний албан нь санхүүгийн байдлын тайланд 1,804.7 сая төгрөгийн газрыг биет бус хөрөнгөөр тайлагнасан боловч үндсэн хөрөнгийн тодруулга тайланд биет хөрөнгөөр бүртгэж толилуулсан, 2019 онд худалдан авсан 18.3 сая төгрөгийн үнэ бүхий санхүүгийн “Veritech” цогц программыг санхүүгийн байдлын тайлан, тодруулгад тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д заасан холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулга хийлгэсэн.

- Нисэх буудлуудын удирдах газар нь өмчийн өөрчлөлтийн тайланд 2018 оны үлдэгдэл, НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны 433.0 сая төгрөгийн залруулгыг тайлагнаж, толилуулаагүй нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, толилуулга ба илчлэл батламж мэдэгдлийг хангаагүй, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” -ын 4-д “Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгалах” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулга хийлгэсэн.

- Газрын тусгай үйлчилгээний албанд ашиглагдаж байсан Соната маркийн 15-26 УБС улсын дугаартай 25.6 сая төгрөгийн суудлын авто машиныг ИНЕГ-ын даргын 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/503 дугаар тушаалаар Баянхонгор аймаг дахь Нисэх

буудалд 2017 онд балансаас баланст шийдвэргүйгээр шилжүүлсэн боловч тухайн байгууллагад бүртгэлгүй байсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4/-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд залруулга хийлгэж, хөрөнгийг бүртгэж тайлагнуулсан.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа зөрчлөөс материаллаг алдаа зөрчлийг дурдвал:

- Баянхонгор аймаг дахь нисэх буудлын удирдлага нь улирлын чанартай ажил эрхэлдэг ажилчдын даатгуулагчаас төлөх НДШ-ийн 0.3 сая төгрөгийг байгууллагаас төлсөн.

- Говь-Алтай аймаг дахь нисэх буудлын удирдлага нь ажилчдын амралтын нөхөн олговрыг илүү, дутуу болон давхардуулан олгосон 3.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- Бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулах ёстой боловч шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн /Чингис хаан Олон улсын нисэх буудал 207.8 сая, Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын газар 159.8 сая/ гэрээ дүгнээгүй 13.0 сая төгрөгийн бараа материалыг гэрээ хийгээгүй шууд худалдан авсан, бараа үйлчилгээг орлого авахаас өмнө төлбөрийг шилжүүлсэн /Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын газар 159.8 сая/.

- Говь-Алтай аймаг дахь Нисэх буудлын газрын эзэмшлийн тээврийн хэрэгсэл нь гэрчилгээгүй, цас цэвэрлэгч машины гэрчилгээ өөр байгууллагын нэр дээр бүртгэлтэй, 2.7 сая төгрөгийн газрын төлбөрийг бүртгэлд тусгаагүй,

- Тайлант оны эцэст барагдуулаагүй нийт 16,809.8 сая төгрөгийн авлага, 278.8 сая төгрөгийн өглөг байна. Үүнээс Чингис хаан Олон улсын нисэх буудлын 12,782.4 сая төгрөгийн авлагын 84.3 хувь буюу 10,810.7 сая төгрөг нь дотоодын авиа компаниудаас авах авлага буюу 2014 оноос өмнө үүссэн 8,576.2 сая төгрөг, 2015 онд үүссэн 407.3 сая төгрөг, 2016 онд үүссэн 42.7 сая төгрөг буюу нийт 9,026.2 сая төгрөгийн насжилт өндөртэй авлага байна.

- Чингис хаан Олон улсын нисэх буудал нь орон нутгийн нисэх буудлууд болон ИНЕГ-ын харьяа байгууллагуудтай холбоотой 93.5 сая төгрөгийн авлага, 240.1 сая төгрөгийн өглөгийг ИНЕГ-ын авлага, өглөгийн систем хоорондын тооцоогоор хааж, бэлэн бус тооцооны хэлбэрээр нэхэмжлэн авахаар тохирч, системийн авлагыг 140.6 сая төгрөгийн цэвэр дүнгээр нэгтгэж толилуулсан.

- Чингис хаан Олон улсын нисэх буудал нь их хэмжээгээр худалдан авч нөөцөлснөөс 15.7 сая төгрөгийн маягт хүчингүй болж үргүй зардал гаргасан.

- Чингис хаан Олон улсын нисэх буудал нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, Нисэх буудлын удирдах газрын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалаар 31.3 сая төгрөгийн хөрөнгийг Нисэх буудлын удирдах газарт хүлээлгэж өгсөн боловч данс бүртгэлээс хасаагүй, жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй.

- Удирдлага буруутай шийдвэр гаргаснаас үндэслэлгүй халагдсан 4 ажилтанд 21.2 сая төгрөгийн нөхөн олговор, тэмдэгтийн хураамжийг төсвөөс олгосон Чингис хаан Олон улсын нисэх буудал 2.7 сая, Баянхонгор аймаг дахь нисэх буудал 18.5 сая/.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тушаалын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Нисэх буудлуудын удирдах газар нь 2020

оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс татан буугдаж, Иргэний нисэхийн үндэсний төв гэсэн нэрээр шинэ зохион байгуулсан байна. Иймд Нисэх буудлуудын удирдах газарт хамаарч байсан алба, салбар, нэгжийн хөрөнгө, авлага, өр төлбөрийн шилжилт, өөрчлөлтийг дараагийн аудитаар хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

